

## Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын алба

Засгийн газрын 1994 оны 229 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албыг "Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу нийслэлийн нийгэм, эдийн засаг, аж ахуйн үйл ажиллагааг удирдан зохицуулах үүрэгтэйгээр 4 хэлтэс 43 хүний орон тоотой байгуулсан.

1994 оны 07 дугаар сарын 07-ний өдрийн Монгол Улсын Их хурлаар "Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль батлагдсан.

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны тухай "Монгол улсын Засгийн газрын 1994 оны 12 дугаар сарын 28-ний өдрийн 229 дүгээр тогтоолоор Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албыг тусад нь зохион байгуулан ажиллуулах болсон нь засаг захиргаа, аж ахуйн үйлчилгээний ажлын ялгаа заагийг тогтооход чухал ач холбогдолтой болсон.

Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 15 дугаар тогтоолыг үндэслэн "Нийслэлийн Засаг даргын 22 тоот захирамжаар Захирагчийн Ажлын албаны бүтцийг шинэчлэн тогтоосон. Захирагчийн ажлын алба нь:

- а/ Инженерийн байгууламжийн хэлтэс
- б/ Үйлдвэрлэл үйлчилгээний хэлтэс
- в/ Хот нийтийн аж ахуйн хэлтэс
- г/ Аялал жуулчлалын хэлтэстэйгээр ажиллаж байсан.

Засгийн газар 2012 оны 12 дугаар сарын 22-ний өдрийн өдөр хуралдаж 190 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2013 оны 1 дүгээр сарын 05-ны өдрийн А/7 дугаар захирамжаар тус албаны бүтэц өөрчлөгдсөн.

Нийслэлийн Засаг даргын бүтцийг шинэчлэн баталсан.  
Шинэчлэн баталсан бүтэцээр нь:

Засгийн газрын тогтоолоор Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны бүтцийг шинэчлэн тогтоосон. Хуучин бүтцээр бол Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны бүтэц нь

- Захиргааны алба
- Инженерийн байгууламжийн хэлтэс;
- Хот, нийтийн аж ахуйн хэлтэс;
- Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтэс;
- Орчны бохирдол, хог хаягдлын менежментийн хэлтэс гэсэн бүтэцтэйгээр ажиллаж байсан бол одоо Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтэс нэмэгдлээ. Ингэснээр Улаанбаатар хотын хог хаягдлыг асуудлыг шинэ менежментээр шийдвэрлэх болж байна. Шинэчлэгдсэн бүтцээр Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба нь:
- Захиргаа санхүүгийн алба
- Инженерийн байгууламжийн хэлтэс
- Хүнс худалдаа үйлчилгээний хэлтэс
- Тохижилт хог хаягдал удирдлагын хэлтэс
- Үйл ажиллагааны мониторингийн хэлтэс гэсэн бүтэцтэйгээр ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын тогтоол 2016 оны 08 дугаар сарын 03 өдрийн дугаар 8 тоот тогтоолын дагуу Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг дараах байдлаар баталсан.

Үндсэн хуулийн Жаран нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсэг, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33.2, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас тогтоох нь:

1. Нийслэлийн удирдлагын бүтцийг дараах байдлаар тогтоосугай:

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны бүтцийг дараах байдлаар тогтоосугай:

- Захиргаа, санхүүгийн хэлтэс;
- Инженерийн байгууламжийн хэлтэс;
- Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс;
- Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтэс.
- Аудит, дотоод хяналтын хэлтэс.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын орон тооны хязгаарыг 129 хүртэл, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны орон тооны хязгаарыг 55 хүртэл, нийслэлийн дүүргийн Засаг даргын Тамгын газрын орон тооны хязгаарыг Баянзүрх, Сонгинохайрхан дүүрэгт тус бүр 68 хүртэл, Баянгол, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй дүүрэгт тус бүр 59 хүртэл, Багануур, Налайх дүүрэгт тус бүр 39 хүртэл (Захирагчийн ажлын албатай), Багахангай дүүрэгт 25 (нормативаар ажиллах орон тоо орохгүй) хүртэл байхаар тогтоосон.